



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Г Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Г
хүлээн авахыг түр зогсоох тухай

Мэргэжлийн зуучлагч байгууллагуудын тоо нэмэгдсээр байгаа боловч “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох суудлын тоо хязгаарлагдмал байгаагаас шалтгаалан Монголын хөрөнгийн биржид гишүүнээр элсэж, арилжаанд оролцох суудлын эрхийг бүх брокер, дилерийн компаниудад олгох боломжгүй байгаа, цаашид үнэт цаасны арилжааны Милленниум Ай Ти системийг суурилуулан ашиглалтанд оруулахаар ажиллаж байгаа зэргийг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.2 дэх заалт, Хорооны 2011 оны 169 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авахыг хүссэн хүсэлтийг хүлээн авахыг 2011 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 сарын хугацаатай түр зогсоосугай.

2. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН